



ДОРНОГОВЬ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар 13/07

Сайншанд сум

Аймгийн 2024 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний жагсаалтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9, 35.1.18, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2, 42.2.1, 42.2.1 /а/ дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 15/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Дорноговь аймгийн 2024 оны төсөв батлах тухай” аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 15/08 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн өөрчлөлтийг 1 дүгээр, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний жагсаалтын өөрчлөлтийг 2 дугаар, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний жагсаалтын өөрчлөлтийг 3 дугаар, Их засварын зардлын хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний жагсаалтыг 4 дүгээр, Замын сангийн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний жагсаалтыг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн 2024 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний өөрчлөлтөд тусгагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай зохион байгуулан гүйцэтгэлийг хангуулан ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Батжаргал)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хорооны ахлагч (Б.Хүдэрболд), аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ц.Батсугир) нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Б.ГАНЗОРИГ

442240053

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн
18/07 дугаар тогтоолын 03 дугаар хавсралт

**АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ӨӨРЧЛӨЛТ**

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжүүлэх хугацаа		Төсөвт өртөг /мян.төг/	2024 онд санхүүжих дүн /мян.төг/	2024 онд санхүүжих төсвийн зохицуулалт /мян.төг/	Нэмэгдэх хасагдах өөрчлөлт /мян.төг/
		Эхлэх	Дуусах				
НИЙТ ДҮН				44,024,826.0	32,094,066.9	32,094,066.9	-
Шинэ хөрөнгө оруулалт							
1	Замын-Үүд сумын 1 дүгээр сургуулийг буулгаж шинээр 960 хүүхдийн сургууль барих ажил	2024	2025	13,520,100.0	6,738,762.0	6,738,762.0	
2	Замын-Үүд суманд Түрээсийн орон сууц хөтөлбөр хэрэгжүүлэх ажил	2024	2024	16,000,000.0	16,000,000.0	14,987,340.0	(1,012,660.0)
3	Сайншанд сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн их засварын ажил	2024	2024	1,878,490.0	950,000.0	1,878,490.0	928,490.0
4	Сайншанд сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн хичээлийн "А" блок, дотуур байрны дотор засал, гэрэлтүүлгийн засварын ажил	2024	2025	798,440.0	400,000.0	400,000.0	
5	Сайншанд сумын 8 дугаар цэцэрлэгийн их засвар ажил	2024	2025	430,385.0	200,000.0	314,536.9	114,536.9
6	Сайншанд сумын 9 дүгээр цэцэрлэгийн дотор засвар гадна фасад засварын ажил	2024	2025	450,000.0	250,000.0	-	(250,000.0)
7	Сайншанд сумын 10 дугаар цэцэрлэгийн гадна фасад, цонхны шинэчлэл засварын ажил	2024	2024	190,000.0	190,000.0	190,000.0	
8	Сайншанд сумын 12 дугаар цэцэрлэгийн дотор засал, гадна фасадын засварын ажил	2024	2024	515,700.0	380,236.9	515,700.0	135,463.1
9	Сайншанд сумын 2 дугаар багийн Дэнж-6 гудамж 618, 620-р байрны (хуучнаар 75 дугаар байр) дээврийн засварын ажил	2024	2024	143,238.0	143,238.0	143,238.0	
10	Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн биеийн тамирын талбайг шинэчлэх ажил	2024	2024	137,000.0	137,000.0	137,000.0	
11	Сайншанд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн баруун талд Нийтийн биеийн тамирын талбай шинээр байгуулах ажил	2024	2025	750,000.0	383,862.0	383,862.0	
12	Аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудад гадна, дотор камер худалдан авах ажил /421*580.0төг/	2024	2024	244,180.0	244,180.0	244,180.0	
13	Сайншанд сумын 2 дугаар багийн Дэнж гудамж 11, 12-р хэсэгт авто зам шинээр хийж төв замтай холбох ажил /1.3 км/	2024	2025	1,848,742.0	1,140,000.0	1,140,000.0	
14	Сайншанд сумын Ноён хутагтын -1 гудамжны 30, 31 дүгээр байрны гадна авто зогсоол барих ажил	2024	2024	334,347.0	334,347.0	334,347.0	
15	Сайншанд сумын Залуучууд-3 гудамжны 36 дугаар байрны зүүн талын автозогсоол, Залуучууд-1 гудамжны 103, 105 дугаар байрны гадна авто зогсоол, тохижилтын ажил	2024	2024	180,000.0	180,000.0	180,000.0	
16	Сайншанд сумын 7 дугаар багийн Ганзамчид-1 дүгээр гудамж 150-р байрны нийтийн эзэмшлийн талбайд явган зам, бетон автозогсоол байгуулах, гэрэлтүүлэг хийх ажил	2024	2024	234,896.0	234,896.0	234,896.0	
17	Сайншанд сумын 2 дугаар багийн "Эрхчөлөө-1" гудамжны 100, 102-р байрны (1, 2 дугаар 58 айл) нийтийн эзэмшлийн талбайд авто зогсоол байгуулах ажил	2024	2024	420,540.0	420,540.0	420,540.0	
18	Сайншанд сумын 8 дугаар багийн Холбооны 4,5,6 дугаар гудамжаар бохир усны шугам татах ажил	2024	2025	550,694.0	225,000.0	225,000.0	
19	Зүүнбаян тосгоны дулааны станцын зуухыг шинэчлэх	2024	2024	250,000.0	250,000.0	250,000.0	
20	Сайншанд сумын дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээг шинэчлэх бараа материал худалдан авах ажил	2024	2024	600,000.0	600,000.0	600,000.0	
21	Сайншанд сумын цэвэр усны өргөх насос станцуудын тоног төхөөрөмжүүдийн шинэчлэлт хийх	2024	2024	344,569.0	344,569.0	344,569.0	